

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

**ГАЗРЫН ТОСНЫ МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН  
АЖЛЫН ДААЛГАВАР**

2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар. УАГ-АД/2025-05 Улаанбаатар хот

**Ажлын зорилго:** Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн 2022, 2023 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын багт газрын тосны нарийн мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан хамтран ажиллана.

**Ажил гүйцэтгэх хугацаа:** 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ.

**Байршил:** Үндэсний аудитын газар

**НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний аудитын газар (цаашид “захиалагч” гэх) Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулна.

**ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ**

Газрын тосны мэргэжлийн зөвлөх шинжээч нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг АДБОУС болон холбогдох журам болон бусад баримт бичигт нийцуулэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газарт, шаардлагатай бол “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Доншен газрын тос Монгол” ХХК, “Петроматад” ХХК-д тус тус ажиллана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэдээллээр тайлан бичнэ. Үүнд:

- Гэрээлэгч газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлтийг газрын тосны олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой боловсруулж, хянасан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд сууринласан дүгнэлт гаргах;
- Гэрээлэгч жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тостой холбоотой үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гаргах;
- Гэрээлэгчийн ашиглалтын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд сууринласан дүгнэлт гаргах;

- Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөгдсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
- Орд ашиглалт, дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төсөвт өргтийг баталгаажуулах санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу олборлосон тосны хэмжээг тулгах болон гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг гэрээлэгчийн үйлдвэрлэлийн талбайд тулган баталгаажуулах;
- Газрын тосны олборлолттой холбоотой илэрсэн бусад нэмэлт шаардлагатай асуудалд дүгнэлт гаргах;
- Шинжээч /шинжээчийн баг/ нь гүйцэтгэсэн ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан эцэслэн гаргах;
- Аудитын тайлангийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэхэд оролцох.

### **ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Шинжээчийн ажилд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, тайландаа үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээ, судалгаанд газрын тосны мэргэжлийн техникийн нэр томьёо, агуулга, орд ашиглалт, дэд бүтэцтэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН**

Шинжээчийн ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

Аудитын үе шат	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй үр дүн
Гүйцэтгэлийн үе шат	1. Гэрээлэгчийн газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлт нь газрын тосны олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөсөн эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	2. Гэрээлэгч жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тостой холбоотой үйл ажиллагааны едөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	3. Гэрээлэгчийн ашиглалтын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	4. Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын талаар нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.
	5. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу олборлосон тосны хэмжээг тулгах болон гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг гэрээлэгчийн үйлдвэрлэлийн бааз дээр тулган баталгаажуулах	Гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг тулган баталгаажуулсан байна.
	6. Орд ашиглалт, дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төсөвт өргтийг баталгаажуулах санхүүгийн зөвлөхийн ажлын тоо хэмжээтэй	Гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг санхүүгийн зөвлөхийн ажлын тоо хэмжээтэй

	үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	тулган баталгаажуулсан байх.
	7. Орд ашиглалтын үйл ажиллагаа Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу үнэн зөв явагдаж байгаа эсэх, газрын тосны нөөцийн тайланг бүртгэж, тайлagnаж хянаж байгаа эсэхэд дүгнэлт гаргасан байна.	Орд ашиглалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, газрын тосны нөөцийн тайлан
	8. Үндэсний аудитын газрын аудитын багаас тодруулах асуудлын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах;	Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан байх
	9. Шинжээч /шинжээчийн баг/ нь гүйцэтгэсэн ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан эцэслэн гаргана.	Шинжээч бие даасан тайлан бичиж, аудитын багт хянуулсан байна.
<b>Тайлагналын үе шат</b>	1. Аудитын тайлангийн төсөл боловсруулах, Аудитын зөвлөлийн хурлаар тайлангийн төсөл хэлэлцүүлэхэд оролцох.	Аудитын тайлан баталгаажсан байна.

## ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд оролцох шинжээч /иргэн, хуулийн этгээд, баг байж болно/ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг гүйцэтгэхэд Үндэсний аудитын газрын аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан газрын тосны мэргэжлийн зөвлөх инженер нь ажил эхлүүлэх болон хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэн захиалагч /Үндэсний аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх явцад шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

## ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх шинжээч нь газрын тосны чиглэлээр ажлын дадлага, туршлагатай, дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан, тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна.

Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хувь хүн байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөхэд дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

### Хуулийн этгээдийн хувьд:

- ✓ Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байх;
- ✓ Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан 2-оос доошгүй жилийн ажлын туршлагатай байх;
- ✓ Геологи, уул уурхай, ашигт малтмалын олон улсын чиг хандлага, газрын тосны технологийн болон үйл ажиллагааны мэдлэг мэдээлэлтэй, ажлын туршлагатай байх.

### Ажиллах хүчиний шаардлага:

- ✓ Газрын тосны чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй;
- ✓ Газрын тосны зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх
- ✓ Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан;
- ✓ Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- ✓ Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- ✓ Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх;
- ✓ Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

**Баг, хувь хүний хувьд:**

- ✓ Багийн ахлагч нь газрын тосны мэргэжлээр зөвлөх инженерийн зэрэгтэй, гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үнэн бодит байдлыг хариуцаж, дүгнэлт гаргах эрх бүхий байх;
- ✓ Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;
- ✓ Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

**ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Газрын тосны мэргэжлийн зөвлөх инженерийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.


ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

  
Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Л.НЯМТӨМӨР  
С.БИЛГҮТЭЙ

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр